



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН ХАРЬЯА
ХОВД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайланд хийсэн
санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: ХОА-2022/09/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:

www.audit.mn

Ховд хот

2023 он

Ховд аймаг дахь Төрийн аудитын газрын дарга,

Тэргүүлэх аудитор: Х.Болдбаатар

Цахим хаяг: Boldbaatar.Kh @audit.gov.mn

Аудитын менежер: А.Цэцэгсүрэн

Утас: 70432545

Цахим хаяг: tsetsegsuren.a@audit.gov.mn

Аудитор: С.Оюунжаргал

Утас: 99911390

Цахим хаяг: Oyunjargals@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ	4
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	10
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	10
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	11
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд.....	12
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв.....	12
3.5.1 Төсвийн төлөвлөлт	12
3.5.2 Төсвийн гүйцэтгэл	12
3.5.3 Нэмэлт төсөв	13
4. АУДИТЫН ТАЙЛАН	13
4.1 Ерөнхий зүйл	13
4.2 Материаллаг байдал	14
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	14
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	14
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	14
4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн	14
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	14
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	15
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	15
Товчилсон үгийн жагсаалт	
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар
ГХУСАЗСЗ	Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл
ШШҮХ	Шүүхийн шинжилгээний үндэсний хүрээлэн
ХХХС	Ховд хөшөөт хөгжил сан



**ХОВД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
84000 Цамбагарав баг, Жаргалант сум, Ховд
Утас: 976-70433061, Факс: 976-70433061
E-mail: khovd@audit.gov.mn

ХОВД АЙМГИЙН ШҮҮХИЙН
ШИНЖИЛГЭЭНИЙ АЛБАНЫ
ДАРГА Б.МӨНХБААТАР ТАНАА

2023.02.24 № 02/43
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Криминалистикийн шинжилгээний чиглэлээр 493 объектод 106 шинжилгээ, тусгай шинжилгээний чиглэлээр 182 объектод 236 шинжилгээ, шүүх эмнэлгийн чиглэлээр хүний биед хийх шүүх эмнэлгийн 979, бэлгийн холбогдолтой 55, цогцост хийх шинжилгээний 74, хавтаст хэргийн материалаар хийх 30 нийт 1480 шинжилгээ хийж дүгнэлт гаргасан байна.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсноор тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Шүүхийн шинжилгээний байгууллагын 2022 оны зорилт, төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн нэгжийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн төлөвлөгөө боловсруулж батлуулан 2022 онд зохион байгуулах сургалт, соён гэгээрүүлэх, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах, хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй, хяналт шалгалтын зэрэг тусгайлсан төлөвлөгөөнүүдийг боловсруулан хэрэгжилтийг хангаж ажиллаж 85.5 хувьтай үнэлэгдсэн байна.

02102030

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ХҮНДЭТГЭСЭН: ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:



Х.БОЛДБААТАР

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	5,549,500.00	13,040,000.00
35	БАРАА МАТЕРИАЛ	5,549,500.00	13,040,000.00
351	Түүхий эд материал	549,500.00	10,640,000.00
35110	Тусгай зориулалттай материал	00.00	10,640,000.00
35130	Эм боох материал	549,500.00	00.00
354	Хангамжийн материал	5,000,000.00	2,400,000.00
35420	Аж ахуйн материал	220,000.00	2,400,000.00
35470	Бусад хангамжийн материал	4,780,000.00	00.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	312,443,159.13	322,345,972.93
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	312,443,159.13	322,345,972.93
391	Газар	00.00	00.00
392	Биет хөрөнгө	285,623,159.13	295,525,972.93
39201	Барилга, байгууламж, орон сууц	188,262,221.86	263,775,914.86
39202	Хуримтлагдсан элэгдэл	-18,887,227.82	-26,325,044.69
39203	Авто-тээврийн хэрэгсэл	40,715,000.00	44,100,000.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	-27,102,986.43	-31,319,444.88
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	73,889,727.74	90,873,967.74
39206	Хуримтлагдсан элэгдэл	-64,689,297.78	-70,707,228.89
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	4,199,214.29	8,075,654.29
39208	Хуримтлагдсан элэгдэл	-2,460,452.58	-3,365,951.26
39214	Бусад үндсэн хөрөнгө	26,275,700.00	26,275,700.00
39215	Хуримтлагдсан элэгдэл	-5,060,404.15	-5,857,594.24
39216	Дуусаагүй барилга, байгууламж	70,481,664.00	00.00
39217	Ном	00.00	00.00
393	Биет бус хөрөнгө	26,820,000.00	26,820,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	26,820,000.00	26,820,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	317,992,659.13	335,385,972.93
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	00.00	00.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	317,992,659.13	335,385,972.93
51	Засгийн газрын хувь оролцоо	317,992,659.13	335,385,972.93
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	61,261,783.00	61,261,783.00
51101	Өмч: - төрийн	34,441,783.00	34,441,783.00
51106	Эздийн өмчийн бусад хэсэг	26,820,000.00	26,820,000.00
512	Хуримтлагдсан үр дүн	166,194,865.38	183,588,179.18
51210	Өмнөх үеийн үр дүн	166,194,865.38	166,194,865.38
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	17,393,313.80
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	90,536,010.75	90,536,010.75
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	317,992,659.13	335,385,972.93

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	384,109,615.86	339,636,140.20
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	40,744,651.86	5,534,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,297,400.00	5,534,800.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	36,447,251.86	00.00
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-ҮХ	00.00	33,150,240.20
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого-БМ	00.00	4,000,000.00
120005	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,364,964.00	296,951,100.00
120005	Улсын төвлөрсөн төсвөөс	267,035,100.00	279,276,800.00
120005	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	267,035,100.00	279,276,800.00
120005	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,329,864.00	17,674,300.00
120005	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,981,664.00	14,550,000.00
120005	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,348,200.00	3,124,300.00
120005	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	295,821,689.20	314,718,034.91
120005	УРСГАЛ ЗАРДАЛ	295,821,689.20	314,718,034.91
120005	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	295,524,289.20	311,307,992.91
120005	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,226,700.00	227,706,600.00
120005	Үндсэн цалин	133,378,800.00	126,453,900.00
120005	Нэмэгдэл	79,767,900.00	79,641,700.00
120005	Унаа хоолны хөнгөлөлт	19,080,000.00	17,701,000.00
120005	Урамшуулал	00.00	3,910,000.00
120005	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,070,900.00	4,790,900.00
120005	Эрүүл мэндийн даатгал	5,070,900.00	4,790,900.00
120005	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,767,500.00	10,832,400.00
120005	Гэрэл, цахилгаан	1,784,636.00	2,447,400.00
120005	Түлш, халаалт	2,405,752.00	7,020,400.00
120005	Цэвэр, бохир ус	1,577,112.00	1,364,600.00
120005	Хангамж, бараа материалын зардал	16,256,200.00	19,404,120.00
120005	Бичиг хэрэг	2,636,200.00	2,602,700.00
120005	Тээвэр, шатахуун	10,100,000.00	12,944,300.00
120005	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	1,363,200.00
120005	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	261,700.00
120005	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	2,232,220.00
120005	Нормативт зардал	4,136,300.00	11,019,800.00

120005	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	4,136,300.00	10,019,800.00
120005	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
120005	Эд хогшил, урсгал засварын зардал	4,578,400.00	1,411,200.00
120005	Багаж, техник, хэрэгсэл	00.00	1,050,000.00
120005	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	361,200.00
120005	Урсгал засвар	4,128,400.00	00.00
120005	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,204,000.00
120005	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,204,000.00
120005	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,240,000.00	15,526,338.00
120005	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,600,000.00	14,082,400.00
120005	Даатгалын үйлчилгээ	330,000.00	223,710.00
120005	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	85,728.00
120005	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	50,500.00
120005	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,000,000.00
120005	Газрын төлбөр	100,000.00	84,000.00
120005	Бараа үйлчилгээний бусад зардал	19,248,289.20	18,412,634.91
120005	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	19,248,289.20	18,412,634.91
120005	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	297,400.00	3,410,042.00
120005	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,874,580.00
120005	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,874,580.00
120005	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	297,400.00	1,535,462.00
120005	Төвлөрүүлэх шилжүүлэг	297,400.00	1,535,462.00
120005	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	<u>88,287,926.66</u>	<u>24,918,105.29</u>
120005	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	00.00	7,524,791.49
120005	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	00.00	7,524,791.49
120005	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	00.00	-7,524,791.49
120005	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	<u>88,287,926.66</u>	<u>17,393,313.80</u>

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	<u>347,662,364.00</u>	<u>302,485,900.00</u>
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	4,297,400.00	5,534,800.00
120	Нийтлэг татварын бус орлого	4,297,400.00	5,534,800.00

120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	4,297,400.00	5,534,800.00
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,297,400.00	5,534,800.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	343,364,964.00	296,951,100.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	267,035,100.00	279,276,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	267,035,100.00	279,276,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	76,329,864.00	17,674,300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,981,664.00	14,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,348,200.00	3,124,300.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	277,180,700.00	302,485,900.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	277,180,700.00	302,485,900.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	276,883,300.00	299,075,858.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	232,226,700.00	227,706,600.00
210101	Үндсэн цалин	133,378,800.00	126,453,900.00
210102	Нэмэгдэл	79,767,900.00	79,641,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	19,080,000.00	17,701,000.00
210104	Урамшуулал	00.00	3,910,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	5,070,900.00	4,790,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	5,070,900.00	4,790,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	5,767,500.00	10,832,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,298,500.00	2,447,400.00
210302	Түлш, халаалт	1,969,000.00	7,020,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,500,000.00	1,364,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	15,680,000.00	20,044,120.00
210401	Бичиг хэрэг	2,000,000.00	2,602,700.00
210402	Тээвэр, шатахуун	10,100,000.00	12,944,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,300,000.00	1,363,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	480,000.00	261,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	2,872,220.00
2105	Нормативт зардал	3,700,000.00	10,470,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,700,000.00	9,470,300.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	00.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	6,198,200.00	361,200.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,619,800.00	00.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	450,000.00	361,200.00
210604	Урсгал засвар	4,128,400.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	3,000,000.00	2,204,000.00
210702	Дотоод албан томилолт	3,000,000.00	2,204,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	5,240,000.00	22,666,338.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	4,600,000.00	21,222,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	330,000.00	223,710.00

210804	Тээврийн хэрэгслийн татвар	150,000.00	85,728.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	60,000.00	50,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	00.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	100,000.00	84,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	297,400.00	3,410,042.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	00.00	1,874,580.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	00.00	1,874,580.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	297,400.00	1,535,462.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	297,400.00	1,535,462.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	<u>70,481,664.00</u>	<u>00.00</u>
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	70,481,664.00	00.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	70,481,664.00	00.00
2200	Дотоод эх үүсвэрээр	70,481,664.00	00.00
220001	Барилга байгууламж	70,481,664.00	00.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	<u>-70,481,664.00</u>	<u>00.00</u>
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	<u>00.00</u>	<u>00.00</u>

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	61,261,783.0	90,536,010.8	85,028,908.1	236,826,701.8
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	00.0	00.0
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,261,783.0	90,536,010.8	85,028,908.1	236,826,701.8
C07	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	-8,171,912.4	-8,171,912.4
C08	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,261,783.0	90,536,010.8	166,194,865.4	317,992,659.1
D01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	61,261,783.0	90,536,010.8	166,194,865.4	317,992,659.1
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.0	00.0	00.0	00.0
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	61,261,783.0	90,536,010.8	166,194,865.4	317,992,659.1
D08	Тайлант үеийн үр дүн	00.0	00.0	17,393,313.8	17,393,313.8
D09	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	61,261,783.0	90,536,010.8	183,588,179.2	335,385,972.9

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	283,276,800.00	283,276,138.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	283,276,800.00	283,276,138.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	283,276,800.00	283,276,138.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	227,706,600.00	227,706,600.00
210101	Үндсэн цалин	126,453,900.00	126,453,900.00
210102	Нэмэгдэл	79,641,700.00	79,641,700.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,701,000.00	17,701,000.00
210104	Урамшуулал	3,910,000.00	3,910,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	4,790,900.00	4,790,900.00
210205	Эрүүл мэндийн даатгал	4,790,900.00	4,790,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	10,832,400.00	10,832,400.00
210301	Гэрэл, цахилгаан	2,447,400.00	2,447,400.00
210302	Түлш, халаалт	7,020,400.00	7,020,400.00
210303	Цэвэр, бохир ус	1,364,600.00	1,364,600.00
2104	Хангамж, бараа материалын зардал	18,794,400.00	18,794,400.00
210401	Бичиг хэрэг	2,602,700.00	2,602,700.00
210402	Тээвэр, шатахуун	12,944,300.00	12,944,300.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,363,200.00	1,363,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	261,700.00	261,700.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,622,500.00	1,622,500.00
2105	Нормативт зардал	10,470,300.00	10,470,300.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	9,470,300.00	9,470,300.00
210502	Хоол, хүнс	00.00	00.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,000,000.00	1,000,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	361,200.00	361,200.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	361,200.00	361,200.00
210604	Урсгал засвар	00.00	00.00
2107	Томилолт, зочны зардал	2,204,000.00	2,204,000.00
210701	Гадаад албан томилолт	00.00	00.00
210702	Дотоод албан томилолт	2,204,000.00	2,204,000.00
210703	Зочин төлөөлөгч хүлээн авах	00.00	00.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	8,117,000.00	8,116,338.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	6,672,400.00	6,672,400.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	00.00	00.00
210803	Даатгалын үйлчилгээ	223,800.00	223,710.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	86,300.00	85,728.00

210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	50,500.00	50,500.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,000,000.00	1,000,000.00
210807	Газрын төлбөр	84,000.00	84,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	283,276,800.00	283,276,800.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	279,276,800.00	279,276,800.00
131001	Улсын төсвөөс санхүүжих	279,276,800.00	279,276,800.00
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	4,000,000.00	4,000,000.0
1200041	Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих	4,000,000.00	4,000,000.0
61	БАЙГУУЛЛАГЫН ТОО	1	1
610001	Төсвийн байгууллага	1	1
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	16	16
620001	Удирдах ажилтан	01	01
620002	Гүйцэтгэх ажилтан	15	15
650002	Төрийн тусгай албан хаагч (ТТ)	16	16

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	17,674,300.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	17,674,300.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	17,674,300.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,249,720.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	14,550,000.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	14,550,000.00
213204	Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал	1,874,580.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	17674300.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	14,550,000.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	3,124,300.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Ховд аймгийн шүүхийн шинжилгээний алба нь гэмт хэрэг зөрчлийг шалгаж тогтоох бусад хэрэг маргааныг хянан шийдвэрлэх ажиллагааны явцад тусгай мэдлэг эзэмшсэн өндөр ур чадвар бүхий шинжээч мэргэжилтнээр дамжуулан тусгай зориулалтын лаборатори болон багаж хэрэгслийн орчинд дэвшилтэт техник технологи, программ хангамж, хүн төрөлхтний шинжлэх ухаан, инженер, техник, урлагийн зэрэг ололт амжилтыг ашиглан холбогдох байгууллага албан тушаалтанд мэргэжлийн туслалцаа үзүүлж үзлэг

шинжилгээ хийж шинжлэх ухааны үндэслэлтэй дүгнэлт гаргах эрхэм зорилго тодорхойлжээ. Дээрх зорилгыг хэрэгжүүлэхээр дараах зорилтуудыг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд:

- Зохих түвшний мэдлэг чадвар туршлагатай мэргэжлийн боловсон хүчнийг бэхжүүлэх
- Зориулалтын лаборатори, байр, багаж хэрэгсэл, программ хангамж, техник технологи, лиценз зөвшөөрөл
- Хууль эрх зүйн орчин
- Хуулийн хүрээнд батлагдсан журам, дүрэм заавар, стандарт норм, нормативыг мөрдөх, мөрдүүлэх
- Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх
- Үйлдэгдсэн гэмт хэргийг халуун мөрөөр нь илрүүлэх
- Гэмт хэрэг зөрчилд холбогдсон этгээдүүдийн гарын мөр, хурууны хээ, галт зэвсэг зэрэг бүртгэл мэдээллийн сан байгуулах

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрдөх Төрийн хэмнэлтийн тухай хууль шинээр батлагдаж хэрэгжиж байна.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Шүүхийн шинжилгээний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль зэрэг хууль тогтоомжуудыг үйл ажиллагаандаа хэрэгжүүлэн ажиллаж байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Байгууллагын даргын 2022 оны А/31 тушаалаар байгуулагдсан өмч хамгаалах зөвлөл тус байгууллагын өмч хөрөнгийн ашиглалт, хадгалалт, хамгаалалтад хяналт тавин ажиллаж байна. Тайлант онд шүүхийн шинжилгээний ерөнхий газраас иж бүрэн шалгалт тус албанд ирж хийгдсэн байна.

Тайлант онд ТӨБЗГ-ын 2022 оны 02 дугаар 22-ны өдрийн 64 дүгээр тогтоолын дагуу шүүхийн шинжилгээний албаны даргын тушаалаар төрийн болон орон нутгийн өмчийн улсын үзлэг, тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсэг 6 хүний бүрэлдэхүүнтэйгээр томилж, тооллогыг зохион байгуулж хөрөнгө бүртгэн авах, актлах хөрөнгийг шийдвэрлүүлэх талаар санал дүгнэлтийг гаргажээ.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шинжилгээний алба нь 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт өөрчлөлт ороогүй байна.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 17.4 сая төгрөгөөр буюу 5 хувиар өссөн байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	/мянган төгрөгөөр/		
	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Бараа материал	5,549.5	13,040.0	7,490.5
Үндсэн хөрөнгө	312,443.2	322,346.0	9,902.8
Нийт хөрөнгө	317,992.7	335,386.0	17,393.3
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	317,992.66	335,385.97	17,393.3
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	317,992.66	335,385.97	17,393.3

Дээрх хүснэгтээс харахад Бараа материал 7490.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн нь аймгийн ГХУСАЗСЗ-ийн санхүүжилтээр 6000.0 мянган төгрөгийн үзлэгийн гэрэл, ШШҮХ-ээс 4000.0 мянган төгрөгийн багаж хэрэгсэл, ХХХС-ийн хөрөнгөөр 2400.0 мянган төгрөгийн хангамжийн материал худалдан авсантай, үндсэн хөрөнгийн дүн өмнөх оноос 9902.8 мянган төгрөгөөр өссөн нь дээд шатны байгууллагаас 33150.2 мянган төгрөгийн өртөгтэй зургийн аппарат, суурин компьютер, ширээ, УАЗ фургон маркийн авто машин шилжүүлж авсан мөн ХХХС-ийн хөрөнгөөр сандал, сейф, ширээ зэрэг хөрөнгө орлогод авч элэгдэл байгуулсантай тус тус холбоотой байна. Засгийн газрын хувь оролцоо 17,393.3 мянган төгрөгөөр тус тус нэмэгдсэн нь үндсэн хөрөнгийн өөрчлөлттэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 279.3 сая төгрөг, өөрийн орлогоос 4.0 сая төгрөг нийт 283.3 сая төгрөгөөр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 279.3 сая төгрөг, өөрийн орлогоос 4.0 сая төгрөг нийт 283.3 сая төгрөгийн санхүүжилт олгосон байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 283.3 сая төгрөг буюу батлагдсан төсвийг зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/сая төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70707/80101-үндсэн үйл ажиллагааны зардал	276.6	276.6	-	100%
2	70707/82311-Тусгай ажил үйлчилгээ	6.7	6.7	-	100%
ДҮН		283.3	283.3	-	100%

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Нэмэлт санхүүжилтийн дансаар аймгийн ГХУСАЗСЗ-өөс 6,000.0 мянган төгрөг, Ховд Хөшөөт хөгжил сангаас 8,550.0 мянган төгрөг, дээд шатны байгууллагаас хуваарилсан давсан орлогоос 3,124.3 нийт 17,674.3 мянган төгрөг бүрдүүлж бараа материал, үндсэн хөрөнгө худалдан авч урсгал засвар байгууллагын ажилтан албан хаагчдад түлшний хөнгөлөлт олгож тайлагнасан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шинжилгээний албаны 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав. Мөн орлогын гүйцэтгэл, хөрөнгө, бараа материалтай холбоотой зөвлөмж тусгасан.

Аудитыг аудитор С.Оюунжаргал 2023 оны 02 дугаар сарын 19-ны өдрөөс 02 дугаар сарын 24-ний хооронд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер А.Цэцэгсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Х.Болдбаатар нар тус тус хэрэгжүүлсэн.

Тус байгууллага нь 2022 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Ховд аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 25-ний өдрийн 12с/53 албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл бага гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2022 оны орлого үр дүнгийн тайлангийн нийт зардлын 321.1 сая төгрөгөөс 1.5 хувиар буюу 4.8 сая төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 3.8 сая төгрөгөөр тогтоосон.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор байгууллага хуулиар хориглосон зардал санхүүжүүлээгүй байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Шилэн дансны цахим системд таван сая төгрөгөөс дээш орлогын 13, зарлагын 2 гүйлгээ өмч хөрөнгө зарцуулахтай холбоотой 1 тушаал шийдвэрийн мэдээллийг бүрэн оруулсан байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар өгөгдсөн 1,850.0 мянган төгрөгийн 2 зөвлөмж өгөгдсөнөөс зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 3 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	1,850.0	2	1,850.0	100.0
Нийт дүн	2	1,850.0	2	1,850.0	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхааран үзэх эрсдэл илрээгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар нийт 13040.0 мянган төгрөгийн алдаа¹ илэрснээс аудитын явцад 13,040.0 мянган төгрөгийн алдааг залрууллаа.

Үүнд: 2022 онд үнэ төлбөргүй авсан 4,000.0 мянган төгрөгийн шинжилгээний багаж, 6,000.0 мянган төгрөгийн үзлэгийн гэрэл, 2,400.0 мянган төгрөгийн ус буцалгагч, шүүгээ гэх мэт бараа материалыг зардлаар бүртгэснийг залруулан тусгай зориулалтай материал болон аж ахуйн материал дансанд бүртгүүлэн залруулга хийв.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		/мянган төгрөгөөр/					
							Үүнээс		Зөвлөмж			
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан	Залруулаагүй	Тоо	Дүн		
Байгууллагын албан хэрэгцээнд ашигладаг бараа материалыг шууд зардлын дансанд бүртгэсэн	1.0	13,040.0	-	-	1.0	13,040.0	1.0	13,040.0	-	-	-	-
Дүн	1.0	13,040.0	-	-	1.0	13,040.0	1.0	13,040.0	-	-	-	-

АУДИТЫН ТАЙЛАНГ ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР:  Х.БОЛДБААТАР

АУДИТЫН МЕНЕЖЕР:  А.ЦЭЦЭГСҮРЭН

ТАЙЛАНГ БИЧСЭН:

АУДИТОР:  С.ОЮУНЖАРГАЛ

¹ Мэдээллийг тусгахгүй орхигдуулах, буруу тусган илэрхийлэх, үүнд, математик үйлдлийн алдаа, НББ-ийн бодлогыг мөрдөхөд гарсан алдаа, бодит байдлыг буруу тайлбарласан /буруу ойлгосон/, хайнга хандсан /мартсан, тэмдэглээгүй орхисон/.